



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 486

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 220,000,000.00 (хоёр зуун хорин сая) төгрөгийн балансын үнэ, 68,749,999.91 (жаран найман сая долоон зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт (Улсын Их Хурлын ажлын албанд) балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

2022.10.13 2022-10-13 13:20:03 088

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
126 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ЗАСГИЙН ГАЗРЫН
АВТОБААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины нэр, улсын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	Ниссан патрол Y-62, 70- 72 УБҮ	2018.05.16	220,000,000.00	68,749,999.91	151,250,000.09
			220,000,000.00	68,749,999.91	151,250,000.09
Нийт дүн			(хоёр зуун хорин сая)	(жаран найман сая долоон зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн нэгэн мөнгө)	(нэг зуун тавин нэгэн сая хоёр зуун тавин мянга есөн мөнгө)